

ТэнГэрЛиг Медиа Групп ХК

2021 оны 8 дугаар сарын 6

№ 21139

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ


*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурал зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ийн өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн хурлыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ийг **2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 11:00 цагт** цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийгэд хүргэх зарын загварыг Гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт материалын жагсаалтыг Дөрөвдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг дэгийг 5-р хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 8 дугаар сарын 27-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2021 оны 8 дугаар сарын 9-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, “Ард Менежемент ҮЦК” ХХК-ийн цахим хуудас, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2021 оны 8 дугаар сарын 11-ны өдрийн дотор нийгэд зарласугай. Давтан зарыг 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг холбогдох бусад баримт бичгийг бэлэн болгож, 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.

7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай
8. Хурлын даргаар “Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Г.Уянгыг томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга:
“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Хандаа
Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн хуулийн зөвлөх Ө.Алхүү
“Тэнгэрлиг Медиа Групп” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичиг
Ч.Хандсүрэн
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
Тооллогын комиссын дарга:
“Сноу Хилл” Консалтанси ХХН ахлах хуульч С.Намжилмаа
Тооллогын комиссын гишүүд:
“Сноу Хилл” Консалтанси ХХН хуульч Д.Номин-Эрдэнэ
“Сноу Хилл” Консалтанси ХХН хуульч Т.Оюун-Эрдэнэ
11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэд даалгасугай.

ДАРГА



Г.УЯНГА